

**БАТЛАВ.
УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Д.СУМЪЯАБАЗАР

Ц.НЯМДОРЖ

**ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ
ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.” гээд тус зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, мөн зүйлийн 2-т “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж тус тус заасан.

1990-ээд оноос эхлэн улс орны эдийн засаг, зах зээлийн харилцаанд гарсан өөрчлөлтийн нэг бол хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах, улмаар энэ төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, худалдах боломжтой болсон явдал юм.

Энэ дагуу үйлдвэрийн зориулалтаар ашиглах тэсэлгээний бодисын зохистой, аюулгүй хэрэглээг нэвтрүүлэх, түүнд тавих хяналт болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн импортыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэх журмыг тогтоосон Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай бие даасан хуулийг 2004 онд батлан мөрдүүлж, улмаар 2013 онд шинэчлэн найруулсан байна.

Өнөөдрийн байдлаар манай улсад үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх худалдах тусгай зөвшөөрөлтэй нийт 64 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.¹

Цаашид манай улсад уул уурхайн салбар улам эрчимтэй хөгжиж ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орсноор тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэглээг дагаж үйлдвэрлэл, импорт нэмэгдэхээр байна.

¹ УУХҮЯ-ны статистик мэдээллээс.

Гэвч тэсрэх материалын агуулахын харуул хамгаалалт сул, тэсэлгээний ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэхгүй байх, шаардлага хангаагүй байр, агуулахад хадгалах, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэх, зарцуулалтын тайлан хөтөлдөггүй, ажилчдыг зохих даатгалд хамруулдаггүй зэрэг зөрчил түгээмэл байна.²

2016-2017 оны байдлаар цагдаагийн байгууллагад тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх 358 хүсэлт ирүүлсний 14% нь буюу 50 тохиолдолд хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүд аюулгүй тээвэрлэлтийн наад захын шаардлагыг хангахгүй байгаа нь тогтоогдсон байна.³

Түүнчлэн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, үйл ажиллагааныхаа талаар зохих журмын дагуу цаг хугацаандаа тайлагнахгүй байх зэргээр хариуцлагагүй хандах нь нийтлэг байна. Тухайлбал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2016 онд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий 5 хуулийн этгээдэд шалгалт хийхэд үйлдвэрийн байр, агуулахад гамшгийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийлгээгүй, аюулгүйн бүс тогтоолгоогүй, зориулалтын агуулах, ачиж буулгах тусгай тоног төхөөрөмж, дотоодын тээврийн хэрэгсэлгүй зэрэг зөрчил илэрсэн бол 2017 оны шалгалтанд хамрагдсан тэсэлгээний ажил эрхэлж байгаа 13 хуулийн этгээдийн хувьд тогтоосон хугацаанд мэдээ, тайланг ирүүлдэггүй, мөн дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтангүй, хяналтыг зохион байгуулах журамгүй үйл ажиллагаа явуулж байсан байна.⁴

Нөгөө талаар тэсэлгээний тусгай зөвшөөрөлгүй компани, хувиараа ашигт малтмал олборлогч иргэд тэсрэх материалыг ашиглах сонирхол их байгаагаас тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хулгайлах, хууль бусаар борлуулах, тэсэлгээ хийх, мөн иргэд баяр ёслол тэмдэглэх зорилгоор пиротехникийн хэрэгсэл ашиглах, хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зөвшөөрөлгүйгээр гар дээрээс худалдаалах зэрэг зөрчил, гэмт хэргийн гаралт төдийлөн буурахгүй байна.

Цагдаагийн байгууллагын статистик мэдээллээс үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг 2016 онд 29, 2017 оны эхний 9 сарын байдлаар 21 бүртгэгдсэн байна.⁵

Түүнчлэн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага давхцалтай, оновчтой бус, мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага, тэсэлгээчний эрхийг олгох, цуцлах журмыг хэн тогтоох нь тодорхойгүй, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг ялган зохицуулаагүй зэргээс хамаарч хуулийн хэрэгжилтэд бэрхшээл үүсч байна.

Тухайлбал, хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтад өөрийн эзэмшлийн газар, галт зэвсэг бүхий харуул хамгаалалтгүй хуулийн этгээдэд тэсэрч дэлбэрэх

² 2017 онд Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Мэргэжлийн зөвлөлийн хийсэн шалгалтын зөвлөмжөөс.

³ ЦЕГ-ийн мэдээллээс. 2017 он.

⁴ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын статистик бүртгэл. 2017 он.

⁵ ЦЕГ-ийн статистик мэдээллээс. 2017 он.

бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон байна.

Гэтэл эзэмшлийн газартай байх шалгуур нь тус хуулийн 11, 12, 13, 15, 16 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл олгоход тавигдах үндсэн шаардлагад тусгагдаагүйн зэрэгцээ тухайн хуулийн этгээдийн эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоогүй ч түүний эзэмшилд хамаардаг бол шаардлага хангасан гэж үзэж болохоор байна.

Мөн гал зэвсэг бүхий харуул хамгаалалтын үндсэн нэгжтэй байхаар шаардлага тавьсан боловч хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт агуулахыг гэрээт харуул хамгаалалтын газраар хамгаалуулахаар заасан байна.

Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох талаар хуульд заагаагүй ч өнөөгийн практикт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас зөвшөөрөл олгож байна.

Өөрөөр хэлбэл, пиротехникийн хэрэгслийг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслээс ялгаатай байхаар хуульд заасан боловч түүнийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах этгээд нь хэн байх, хаанаас ямар зөвшөөрөл авахыг тодорхойлоогүй тул холбогдох дүрмээр⁶ энэ эрхийг хувь хүнд ч олгож болохоор байна.

Одоогийн байдлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь пиротехникийн хэрэгслийг тэсэрч, дэлбэрэх бодистой адилтган үзэж импортлох, худалдах зөвшөөрөл 2, ашиглах зөвшөөрөл 1-ийг тус тус олгосон байна.⁷

Түүнчлэн тэсрэх бодисын эргэлтэд хяналт тавих байгууллагуудын хяналтыг сайжруулах, тэр дундаа тэсрэх бодис үйлдвэрлэх, хадгалалтын үеийн галын аюулгүй байдал, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас тавих хяналт, оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна.

Иймд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих шаардлагыг оновчтой тогтоох, ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн хяналтыг сайжруулах шаардлага тулгарч байна.

Үүнийг харгалзан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд⁸ “Хууль сахиулах байгууллагаас тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэнд тавих хяналтыг сайжруулах” зорилгыг⁹ дэвшүүлж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа,хамрах хүрээ

Тус хуулийн төслөөр өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд дараахь нэмэлт, өөрчлөлтийг тусгана:

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

⁷ УУХҮЯ-ны статистик мэдээллээс.

⁸ Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоол.

⁹ Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 152.

- 1) Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих шаардлагыг тодорхой болгохын зэрэгцээ үйл ажиллагааны төрлийн онцлогоос хамаарч ялгамжтай тогтооно.
- 2) Пиротехникийн хэрэгслийг хүчин чадлаас нь хамаарч ангилах бөгөөд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйлдвэрлэх, импортлох болон үзвэр, үйлчилгээний зориулалтаар ашиглахаар хуульчилна. Мөн пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах эрхийг иргэнд бус зөвхөн хуулийн этгээдэд олгохоор зохицуулна.
- 3) Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцаж буй хүний нөөц, тэсэлгээчин, пиротехникийн хэрэгслийн операторчныг бүртгэлд хамруулж, мэргэжлийн шаардлага болон даатгалын системийн хэрэгжилтийг сайжруулна.
- 4) Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, үүрэг хүлээгч байгууллагуудын чиг үүргийг тодруулах, тэр дундаа хууль хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүргийг нарийвчилж, цагдаагийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.
- 5) Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт, хяналттай холбоотой харилцааг зохицуулах нарийвчилсан дүрэм, журам батлах эрх шилжүүлсэн зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар хууль нэг мөр хэрэгжих баталгаа хангагдана.

Түүнчлэн энэ чиглэлээр төрийн хяналт сайжирч, хууль хоорондын давхардал, хийдэл арилахын зэрэгцээ уул уурхайн болон барилгын салбарын үйл ажиллагаа хариуцлагатай, нийгэм байгальд ээлтэй болж сайжирна.

Хууль батлагдсаны дараа улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан салбарын хуулиудтай уялдуулан боловсруулна.